

ОЮУ ТОЛГОЙ ХХК-ИЙН УУЛ УУРХАЙН АЖИЛТНЫ ҮЙЛДВЭРЧНИЙ ЭВЛЭЛИЙН ХОРООНЫ ДОТООД ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Оюу толгой ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Монгол улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаагаа явуулж буй сайн дурын, гишүүдийнхээ эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллага мөн.
- 1.2 Оюу толгой ХХК-ийн уул уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо нь сайн дураараа эвлэлдэн нэгдэж, татвараа төлж буй гишүүдээс бүрдэнэ.
- 1.3 Англи нэр нь Trade Union Committee of Oyu tolgoi LLC’s mining employees. Монгол нэр нь Оюу толгой ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо.
- 1.4 Оюу толгой ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Монгол Улсын Үндсэн Хууль, Үйлдвэрчний эвлэлийн эрхийн тухай хууль болон холбогдох бусад хууль, олон улсын гэрээ, Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбооны дүрмийн хүрээнд Оюу Толгой ХХК-ийн үйл ажиллагааны онцлогт тохируулан үйл ажиллагаагаа явуулдаг.
- 1.5 Мөн тус Үйлдвэрчний эвлэлийн хороо нь хуулийн этгээд бөгөөд туг, онцлох тэмдэг, албан бичгийн хуудас, дуу, уриа, тамга, тэмдэг, шагнал, хэвлэлтэй байна.
- 1.6 Оюу толгой ХХК-ийн Уул, уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороо нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын хуулийн этгээдийн бүртгэлийн газраас олгосон гэрчилгээтэй байна.

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

- 2.1 “ҮЭ-Үйлдвэрчний эвлэл” гэж Оюу толгой ХХК-ийн уул уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн хороог хэлнэ.
- 2.2 “МҮЭ” гэж Монголын Үйлдвэрчний эвлэлийг хэлнэ.
- 2.3 АО-ажил олгогч гэж Оюу Толгой ХХК-ийг хэлнэ.
- 2.4 “Гишүүн” гэж энэхүү дүрмийг хүлээн зөвшөөрсөн, ҮЭ-д бүртгэлтэй, гишүүний татвараа бүрэн төлж буй Оюу Толгой ХХК-ийн үндсэн ажилтанг; /хугацаатай болон хугацаагүй гэрээтэй/
- 2.5 “Тэргүүлэгч гишүүн” гэж ҮЭ-ийн гишүүдээс төлөөлж удирдах зөвлөлд сонгогдсон эрх бүхий сонгуульт гишүүн;
- 2.6 “ҮЭ-ийн Удирдах зөвлөл” гэж ҮЭ-ийн бүх тэргүүлэгч гишүүдээс бүрдсэн эрх барих дээд байгууллага;
- 2.7 “ҮЭ-ийн Удирдах зөвлөлийн дарга” гэж Удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаар сонгуульт хугацаанд сонгогдсон тэргүүлэгч гишүүн;
- 2.8 “ҮЭ-ийн хорооны дарга” гэж ҮЭ-ийн өдөр тутмын үйл ажиллагааг зохион байгуулах зорилгоор Удирдах зөвлөлтэй гэрээгээр ажиллах Оюу Толгой ХХК ажилтан бус, эрх бүхий этгээд;

- 2.9 “ҮЭ-ийн хорооны нягтлан бодогч ” гэж ҮЭ-ийн санхүүгийн гүйлгээг хариуцдаг эрх бүхий этгээд;
- 2.10 “ҮЭ-ийн даргын туслах ” гэж ҮЭ-ийн албан хэрэг хөтлөлт, тамгыг хадгалах эрх бүхий этгээд;
- 2.11 “Хяналтын Зөвлөл” гэж ҮЭ-ийн журам дүрмүүдийн хүрээнд эдийн засгийн болон үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий хараат бус бие даасан сонгуульт гишүүдийг.

Гурав. Үйлдвэрчний эвлэлийн зорилго, зорилтууд

- 3.1 ҮЭ-ийн үндсэн үйл ажиллагаа нь гишүүдийнхээ ашиг сонирхол, хөдөлмөрлөх нөхцөл болон эрхийг хуулийн хүрээнд хамгаалж, сайжруулах зорилготой.
- 3.2 Гишүүдийн хөдөлмөрийн, нийгмийн, мэргэжлийн болон бусад ашиг сонирхлыг төлөөлнө.
- 3.3 ҮЭ-ийн гишүүнчлэлээс үл хамааран нийт ажилтны олонхын эрх ашгийг төлөөлөн хамгаалах.
- 3.4 ҮЭ-ийн зорилтуудыг биелүүлэхэд доорх зүйлсийг хэрэгжүүлднэ:
 - 3.4.1 Ажил олгогч болон төрийн байгууллагуудад нийгэм, эдийн засаг, хөдөлмөр, хөдөлмөр хамгаалал, хөдөлмөр эрхлэлт болон бусад асуудлын хүрээнд шаардлага тавих;
 - 3.4.2 Монгол улсын хуулийн хүрээнд гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон ашиг, сонирхлыг хөндөж буй асуудлаар хууль тогтоомж, дүрэм журмын төсөл боловсруулахад оролцох, санал оруулах;
 - 3.4.3 ҮЭ-ийн гишүүдийн эрх ашгийг гурван талт хэлэлцээрт төлөөлөх, хамтын гэрээ болон тохиролцоо байгуулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт тавих;
 - 3.4.4 Салбарын ажил олгох төрийн бодлого боловсруулахад оролцох, гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон ашиг, сонирхлыг хөндөж буй асуудлаар хууль тогтоомж, дүрэм журмын төсөл боловсруулахад оролцох, санал оруулах;
 - 3.4.5 Хөдөлмөрийн хамтын маргааныг зохицуулахад оролцож хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан, ажил хаялт, пикет болон хамтын тэмцлийн бусад ажиллагааг зохион байгуулж, ҮЭ-ийн хамтын тэмцэл, үйл ажиллагааг дэмжих, дэмжлэг туслалцаа авах;
 - 3.4.6 Ажил олгогч хөдөлмөрийн хууль, хөдөлмөр хамгаалал, мэргэжлийн хяналтын стандартуудыг хэрхэн мөрдөж байгаад нь хяналт тавих;
 - 3.4.7 Хөдөлмөр хамгаалал, мэргэжлээс шалтгаалсан өвчин, экологийн асуудлаар салбарын болон ажил олгогчийн бодлого боловсруулахад оролцох;
 - 3.4.8 Хууль тогтоох, гүйцэтгэх шүүх засаглалын байгууллагуудад, хөдөлмөрчид, ҮЭ-ийн гишүүдийн эрх ашгийг төлөөлөн хамгаалуулах, хамтын үйл ажиллагаа, жагсаал цуглаан, ажил хаялт, пикет зохион байгуулах үед дэмжлэг туслалцаа авах;
 - 3.4.9 ҮЭ-ийн өмч хөрөнгийг захиран зарцуулах, ажил хаялтын, нийгмийн хамгааллын, сургалтын болон бусад санг байгуулах;
 - 3.4.10 ҮЭ-ийн хороо нь идэвхтэй гишүүд, ажилтнуудаа шагнаж урамшуулах, шагнал урамшуулалд тодорхойлуулах;
 - 3.4.11 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр үйл ажиллагаагаа сурталчлах;

3.4.12 Хуулиар хориглоогүй бусад үйл ажиллагааг явуулах;

Дөрөв. Үйлдвэрчний эвлэлийн гишүүн түүний эрх, үүрэг, хариуцлага

4.1 ҮЭ-ийн хорооны гишүүн нь МҮЭ-ийн холбоонд гишүүнчлэлтэй салбарын ҮЭ-ийн гишүүний нэг загварын батлахтай байх бөгөөд өөр ҮЭ-ийн гишүүн байж үл болно.

Гишүүд нь дор дурьдсан эрхийг эдэлнэ:

- 4.2 ҮЭ-р дамжуулан нийгэм, эдийн засаг, хувь хүний эрхийн болон хөдөлмөрийн асуудалтай холбоотой хууль ёсны эрх ашгаа хуулийн дагуу хамгаалуулах;
- 4.3 ҮЭ-ийн үйл ажиллагаа, үндсэн чиглэл, бодлого боловсруулахад оролцох, үзэл бодол, байр сууриа илэрхийлэх;
- 4.4 Хууль зүйн зөвлөгөө авах;
- 4.5 Шаардлагатай үед ҮЭ-ээс оюун санаа, эд материалын тусламж хүсэх;
- 4.6 МҮЭ болон ҮЭ-ийн сургалт, соёл үйлчилгээний байгууллагаар хөнгөлөлттэй үйлчлүүлэх;
- 4.7 ҮЭ-ийн тэргүүлэгч гишүүнийг сонгох, тэргүүлэгч гишүүнээр сонгогдох, нэрээ дэвшүүлэх, татгалзах;
- 4.8 ҮЭ-ийн гишүүнээс гарах, дахин элсэх.
- 4.9 Холбогдох хууль тогтоомжид заасан бусад;

Гишүүд нь дор дурьдсан үүргийг хүлээнэ:

- 4.10 ҮЭ-ийн дүрмийг чанд баримтлах, бодлого шийдвэрийг дэмжин хэрэгжүүлэх, үйл ажиллагааны чиг баримтлал бодлого шийдвэрийг бусдадаа сайн дураар мэдээлэх;
- 4.11 ҮЭ-ийн татварыг тогтоосон хугацаанд нь төлөх;
- 4.12 ҮЭ-ээс зохион байгуулж байгаа арга хэмжээнд оролцох;
- 4.13 Сонгуульт ажилтнаар сонгогдвол хариуцлагатайгаар ажиллах;
- 4.14 ҮЭ-ийн үйл ажиллагаанд санаатайгаар сөргөөр нөлөөлөхгүй байх, ҮЭ-ийн нэр хүнд хууль ёсны эрх ашгийг хөндөхгүй байх

Гишүүнээр элсэх

- 4.15 Загвар маягтын дагуу элсэх хүсэлтээ бичгээр гаргаж, татвараа төлж эхэлснээр гишүүний эрх нээгдэнэ.
- 4.16 ҮЭ-ийн батлах болон системд бүртгүүлсэнээр МҮЭ-н гишүүдийн бүртгэлд орно.

ҮЭ-ийн гишүүдийн шагнал урамшуулал

- 4.17 ҮЭ-ийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцсон гишүүдийг дараах байдлаар шагнаж урамшуулна.
- Баярын бичиг
 - Мөнгөн шагнал
 - Дурсгалын зүйлс
 - МҮЭ-ийн салбарын, улсын шагналд нэр дэвшүүлэх

- 4.18 Гишүүдийг тэргүүлэгч гишүүн нь шагнал урамшуулалд тодорхойлж Удирдах зөвлөлд танилцуулан олонхын саналаар дэмжигдсэнээр АО болон дээд шатны байгууллагад саналаа оруулна.

ҮЭ-ийн гишүүдийн хариуцлага

- 4.19 ҮЭ-ийн байгууллагын дотоод журамыг зөрчсөн тохиолдолд доорх сахилгын арга хэмжээг шат дараалан авна Үүнд:
- 4.19.1 Анхааруулга;
 - 4.19.2 Бичгийн сануулга;
 - 4.19.3 Гишүүний эрхийг түдгэлзүүлэх;
- 4.20 Гишүүний эрхийг доорх тохиолдолд түдгэлзүүлнэ.
- 4.20.1 4.13 заалтыг ноцтой зөрчсөн нь тогтоогдсон бол;
 - 4.20.2 Энэхүү дүрэм болон ҮЭ-ийн удирдах байгууллагын журмыг 2 болон түүнээс дээш зөрчсөн тохиолдолд;
 - 4.20.3 Гишүүн өөрөө хүсэлт гаргасан
- 4.21 Энэхүү дүрмийн 4.19-т заасны дагуу гишүүний эрхийг түдгэлзүүлэх эсэхийг Удирдах зөвлөлийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

Тав. ҮЭ-ийн Удирдах зөвлөл түүний эрх, үүрэг, хариуцлага

Удирдах зөвлөл

- 5.1 ҮЭ-ийн хорооны үйл ажиллагааг хамтын удирдлагаар хангах, бүх гишүүдийг төлөөлж шийдвэр гаргах эрх бүхий байгууллага нь Удирдах зөвлөл байна. Удирдах зөвлөл нь сондгой тооны бүрэлдэхүүнтэй байх ба сонгуулийн журамд бүрэлдэхүүний тоог батална.
- 5.2 Удирдах зөвлөлийн гишүүдийг харьяа тойргийн гишүүдээс нээлттэйгээр санал хурааж 2 жилийн хугацаагаар сонгох ба тойргийн тоог сонгуулийн журмаар батална.
- 5.3 Удирдах зөвлөлийн гишүүдийн сонгуулийг хэсэгчлэн зохион байгуулж болох ба хэсэгчлэн зохион байгуулах үед Хяналтын зөвлөлийн гишүүд хөндлөнгийн хяналтаар оролцож баталгаажуулна.
- 5.4 Удирдах зөвлөлийн хурлыг сард нэгээс доошгүй удаа, шаардлагатай үед хугацаа үл хамааран хуралдуулна. Хурал гишүүдийн 50 хувиас дээш ирцтэй тохиолдолд хүчинтэйд тооцох бөгөөд онлайн болон утсаар явуулж болно. Хурлыг Удирдах зөвлөлийн дарга эсвэл тухайн хурлын хамгийн ахмад настай тэргүүлэгч удирдаж явуулна.

Удирдах зөвлөлийн эрх

- 5.5 ҮЭ-ийн бүтэц, орон тоо, төлөвлөгөө, төсвийг боловсруулж хянаж, батлах;
- 5.6 ҮЭ-ийн хорооны даргыг томилох, (хугацаатай хөдөлмөрийн гэрээ)
- 5.7 ҮЭ-ийн нябо болон даргын туслах ажилтанг томилох;
- 5.8 ҮЭ-ийн дотоод журам болон ёс зүйн дүрмийг хянах, шинэчлэх, батлах;

- 5.9 ҮЭ-ийн сонгуулийн журам, ёс зүйн журам болон санхүүгийн, албан бичиг хөтлөлтийн болон бусад шаардлагатай журмыг батлах, шинэчлэх.
- 5.10 Хяналтын зөвлөлийн гишүүдийн сонгуулийг зохион байгуулах, сонгогдсон гишүүнийг баталгаажуулах.
- 5.11 Гишүүдийнхээ хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах, дүрэм, журам хууль тогтоомжийн төсөл боловсруулахад санал өгөх
- 5.12 ҮЭ-ийн хөрөнгө, эд хогшил, ажил хаялт, нийгмийн хамгаалал, сургалтын болон бусад сангийн захиран зарцуулалтыг батлах, хянах, шалгах.
- 5.13 ҮЭ-ийн, салбарын, төрийн, мэргэжлийн болон бусад холбогдох шагналд нэр дэвшигчдийг тодорхойлох
- 5.14 Ажил олгогчтой хамтын маргаан үүсгэн шийдвэрлүүлэх, хамтын үйл ажиллагаа, жагсаал цуглаан, ажил хаялт, пикет зохион байгуулах, удирдах.

Удирдах зөвлөлийн үүрэг

- 5.15 ҮЭ-ийн үйл ажиллагааны бодлого, төлөвлөгөөг баталж, хянах.
- 5.16 ҮЭ-ийн журмууд болон ёс зүйн дүрмийг чандлан мөрдөх.
- 5.17 Ажил олгогчтой хийх хамтын гэрээний төсөл боловсруулж харилцан батлах түүний хэрэгжилтэд хяналт тавих.
- 5.18 МҮЭ-ийн болон салбарын ҮЭ-ээс зохион байгуулсан аливаа арга хэмжээнд байгууллага хамт олноо төлөөлөх болон зохион байгуулж оролцох.
- 5.19 ҮЭ-ийн хорооны даргын ҮЭ-ийн бодлогын хүрээнд хэрэгжүүлж буй ажлуудыг дэмжиж ажиллах.
- 5.20 Ажил олгогчийн зүгээс хөдөлмөр, нийгэм хамгааллын хууль тогтоомжийг биелүүлэн хэрэгжүүлж буй байдалд хяналт тавьж мэргэжлийн хяналтын байгууллага, хөдөлмөрийн нөхцөлийн бусад стандарт нормативын асуудлаар хяналт тавихад нь төлөөлөгчөөр оролцох
- 5.21 ҮЭ-ийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, гишүүдэд сурталчлах ажлыг зохион байгуулах.
- 5.22 ҮЭ-ийн үйл ажиллагааг ил тод явуулах.
- 5.23 Бүх гишүүдийн хурал зохион байгуулах шийдвэр гаргах, тухайн хурлыг удирдан явуулахад оролцох, гаргасан шийдвэр тогтоолыг хэрэгжүүлэх.
- 5.24 Бүх гишүүдийн хуралд ҮЭ-ийн үйл ажиллагааг жилд 1 удаа тайлагнах.
- 5.25 ҮЭ-ийн гишүүдийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, тэдгээрийн шийдвэрийн тухай бүрт мэдэгдэх.
- 5.26 Тойргийн гишүүдэд жилд хоёроос доошгүй удаа үйл ажиллагаагаа тайлагнах.
- 5.27 Тойргийн гишүүдийн татвар төлөлтөд хяналт тавих, гишүүнчлэлийг нэмэгдүүлэхэд идэвхи санаачлагатай оролцох.

Удирдах зөвлөлийн хариуцлага

- 5.28 Удирдах зөвлөлийн гишүүний эрхийг доорх тохиолдолд түдгэлзүүлнэ.
 - 5.28.1 Энэхүү дүрэм болон ҮЭ-ийн удирдах зөвлөлөөс гаргасан шийдвэр, ёс зүйн дүрмийг 2 болон түүнээс дээш зөрчсөн тохиолдолд

- 5.28.2 Байгалийн давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан эрхээ түдгэлзүүлж байгаа тохиолдолд нөхөн сонгуулийг удирдах зөвлөл ажлын хэсэг томилж удирдан зохион байгуулах.
- 5.29 Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг олонхын саналаар шийдвэрлэж, хурлын тогтоолоор баталж гаргана. Удирдах зөвлөлийн гишүүн нь хүндэтгэн үзэх шалтгаанаар үүрэгт ажлаас чөлөөлөгдөх тохиолдолд ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ 30 хоногийн дотор бичгээр гаргаж өгнө. Ажлаас чөлөөлөгдөх хүсэлт болон өргөдөлөө дээрх хугацаанд гаргаж өгөөгүй тохиолдолд Удирдах Зөвлөлийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж тухайн тэргүүлэгчийг үүрэгт ажлаас чөлөөлөх тогтоол гаргана. Удирдах Зөвлөлийн гишүүний нөхөн сонгуултай холбоотой харилцааг Сонгуулийн журмаар зохицуулна.
- 5.29.1 ҮЭ-ийн гишүүний хариуцлагын заалтууд давхар хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 5.29.6 ҮЭХ гишүүдийн хувь хүний нууцад хамаарах мэдээллийг олон нийтэд тараах, задруулах, ҮЭХорооны дарга, тэргүүлэгч гишүүн, албан тушаалтнаас бусад хүмүүст мэдээлэх
- 5.29.7 Хувийн ашиг сонирхлоор ҮЭХорооны үйл ажиллагааг гутаан доромжлох, олон нийтэд ҮЭХорооны талаар буруу ташаа, сөрөг мэдээлэл хүргэх
- 5.29.8 Долоо хоног бүрийн тэргүүлэгч гишүүдийн хурлыг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сард 2 ба түүнээс дээш удаа таслах
- 5.29.9 Тэргүүлэгч гишүүн ажлаа хангалтгүй хийсэн гэж үзэж тухайн тойргийн нийт гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь эгүүлэн татах санал гаргасан
- 5.30.1 ҮЭ-ийн өмч хөрөнгө, нэр хүндийн эсрэг санаатай болон санамсаргүй хийсэн үйл ажиллагаанд ногдуулах хариуцлагыг Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

Зургаа. ҮЭ-ийн хорооны дарга түүний эрх, үүрэг, хариуцлага

ҮЭ-ийн хорооны дарга

- 6.1 Удирдах зөвлөлийн гишүүдийн хурлаас томилогдсон эрх бүхий этгээд.
- 6.2 Удирдах зөвлөлийн хурлаас баталсан хөтөлбөр, төсвийн хүрээнд ажлуудыг зохион байгуулж, хэрэгжүүлэх эрх бүхий этгээд.
- 6.3 ҮЭ-ийн хорооны даргаар ажиллах хугацаатай хөдөлмөрийн гэрээ нь 1 жил хүртэлх хугацаатай байна.
- 6.4 ҮЭ-ийн хорооны даргын нууцлалын гэрээ болон бусад гэрээ нь 5 жил хүртэлх хугацаатай байна.

ҮЭ-ийн хорооны даргын эрх

- 6.5 Удирдах зөвлөлд тухайн жилд, улиралд хийх ажлын төлөвлөгөө, төсвийг танилцуулж батлуулах.
- 6.6 Удирдах зөвлөлийн хурлаас баталсан хөтөлбөр, төсвийн хүрээнд ажлуудыг хэрэгжүүлэх, хянах.
- 6.7 ҮЭ-ийн хорооны өдөр тутмын үйл ажиллагааг хэвийн үргэлжлүүлэхтэй холбоотой аливаа асуудлыг Удирдах зөвлөлд оруулж, тогтоол гаргуулах.
- 6.8 ҮЭ-ийн санхүүгийн журмын дагуу батлагдсан ажлын төлөвлөгөөнд тусгагдсан төсвийг хянан зарцуулах.
- 6.9 ҮЭ-ийн гадаад харилцаа болон МҮЭ-д Оюу толгой ХХК-ийн уул уурхайн ажилтны Үйлдвэрчний эвлэлийн ашиг сонирхлыг төлөөлөх.

- 6.10 АО-той хийх уулзалт, харилцааг бүрэн удирдаж төлөөлөх.
- 6.11 Батлагдсан ажлын төлөвлөгөөний хүрээнд захиргааны шийдвэр гаргах.
- 6.12 Туслах ажилтан ба няботой холбогдох гэрээг байгуулах.
- 6.13 ҮЭ-ийг төлөөлж хэлэлцээрийн гэрээнд Удирдах зөвлөлийн чиглэлийн дагуу гарын үсэг зурах.
- 6.14 Удирдах зөвлөлд санал бодлоо илэрхийлэх, санал санаачлагыг танилцуулж, батлуулах.

ҮЭ-ийн хорооны даргын үүрэг

- 6.15 Бүх гишүүдийн болон Удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.
- 6.16 ҮЭ-ийн хорооны дарга ажлаа бүх гишүүдэд жилд 1-ээс доошгүй удаа, Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд улиралд 1 удаа тайлагнана.
- 6.17 ҮЭ-ийн гишүүд, Удирдах зөвлөлөөс дэвшүүлсэн хууль ёсны ашиг сонирхлыг илэрхийлсэн аливаа асуудлыг ажил олгогч, төр, захиргааны байгууллагуудад төлөөлөн оролцож байр сууриа илэрхийлэх, санал, дүгнэлт, шаардлага хүргүүлэх, хэрэгжилтийг хангуулах.
- 6.18 ҮЭ-ийн үйл ажиллагааг Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд ил тод мэдээлэх, явуулах.
- 6.19 Хамтын гэрээний хэрэгжилтийг хянаж, хэрэгжүүлэх бүх талын ажлыг хангаж ажиллах.
- 6.20 Бүх гишүүдийн хурал зохион байгуулах санал гаргах, тухайн хурлыг удирдан явуулах.
- 6.21 ҮЭ-ийн гишүүдийн санал гомдлыг хүлээн авч шийдвэрлүүлэх ажлыг зохион байгуулах, тэдгээрийн шийдвэрийн тухай бүрт мэдэгдэх.
- 6.22 ҮЭ-ийн өдөр тутмын ажлыг зохион байгуулах, нябо, туслах ажилтны ажлыг чиглүүлэн удирдах.
- 6.23 ҮЭ-ийн үйл ажиллагааг хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, гишүүдэд таниулах ажлыг зохион байгуулах.
- 6.24 Хөдөлмөрийн гэрээ, ҮЭ-ийн дотоод журам болон ёс зүйн дүрмийг чандлан мөрдөх.

ҮЭ-ийн хорооны даргын хариуцлага

- 6.25 ҮЭ-ийн хорооны даргыг хугацаанаас нь өмнө доорх тохиолдолд түдгэлзүүлнэ:
 - 6.25.1 ҮЭ-ийн дотоод журам болон ёс зүйн дүрмийг зөрчсөн тохиолдолд Удирдах зөвлөлөөр авч хэлэлцэх,
 - 6.25.2 ҮЭ-ийн хорооны нийт тэргүүлэгч гишүүдийн гуравны хоёр нь ҮЭ-ийн хорооны даргыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл бүхий санал ирүүлсэн тохиолдолд хурлаар авч хэлэлцэн олонхын саналаар.
 - 6.25.3 Өөрийн саналаар болон хүндэтгэн үзэх шалтгаан эсхүл гэнэтийн хүчин зүйлээс хамааран.
 - 6.25.4 ҮЭ-ийн өмч хөрөнгө, нэр хүндийн эсрэг ямар нэгэн санаатай болон санамсаргүй хийсэн үйл ажиллагаанд ногдуулах хариуцлагыг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээг мөрдлөг болгож Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

Долоо. ҮЭ-ийн хорооны даргын туслах ажилтаны үүрэг, хариуцлага

- 7.1 ҮЭ-ийн бүх гишүүдийн бүртгэлийг хариуцах, татвар төлөлтөд сар бүр хяналт тавих.
- 7.2 ҮЭ-ийн Мэдээлэл, бичиг баримт, архив хөтлөлтийн журмыг дагаж мөрдөх.
- 7.3 ҮЭ-ийн тамгыг аюулгүй, найдвартай хадгалах
- 7.4 Мэдээлэл, бичиг баримт, архивын журмын дагуу зөвхөн шаардлага хангасан баримт бичигт тамга дарж, эх хувийг хадгалах,
- 7.5 Удирдах зөвлөлийн тогтоолын төслийг бэлдэж, танилцуулан, батлуулах.
- 7.6 Удирдах зөвлөл, ҮЭ-ийн хороон дарга болон Хяналтын зөвлөлийн аливаа хурал уулзалтуудын тэмдэглэл хөтлөн, архивлах.
- 7.7 Бүх гишүүдийн хурал, уулзалт, гишүүдэд чиглэсэн арга хэмжээний үйл явцыг баримтжуулж, хурлын тэмдэглэл хөтлөх.
- 7.8 ҮЭ-ийн бүх үйл ажиллагааг Хяналтын зөвлөлд ил тод мэдээлэн, явуулах
- 7.9 ҮЭ-ийн дотоод журам, ёс зүйн дүрмийг чанд мөрдөх
- 7.10 ҮЭ-ийн хорооны даргын туслахыг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө түдгэлзүүлнэ:
 - 7.10.1 Энэхүү дотоод журам болон хөлсөөр ажиллах гэрээг зөрчсөн
 - 7.10.2 Өөрийн саналаар болон гэнэтийн хүчин зүйлээс хамааран
 - 7.10.3 Нийт тэргүүлэгч гишүүдийн гуравны хоёроос илүү нь ҮЭ-ийн хорооны даргын туслахын үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл бүхий саналыг зөвшөөрсөн тохиолдолд
 - 7.10.4 ҮЭ-ийн өмч хөрөнгө, нэр хүндийн эсрэг ямар нэгэн санаатай болон санамсаргүй хийсэн үйл ажиллагаанд ногдуулах хариуцлагыг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээг мөрдлөг болгож Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

Найм. ҮЭ-ийн хорооны нягтлан бодогчийн үүрэг, хариуцлага

- 8.1 ҮЭ-ийн гишүүдийн татвар төлөлтийг хянан, баримтжуулах.
- 8.2 Санхүүгийн журмын дагуу Удирдах зөвлөлийн тогтоол болон ҮЭ-ийн хорооны даргын тушаалаар гарсан шийдвэрийг үндэслэн ҮЭ-ийн хорооны санхүү, мөнгөн хөрөнгийг үр ашигтай зарцуулж, эд хөрөнгийн бүртгэл хөтөлнө.
- 8.3 Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд ҮЭ-ийн хорооны тайлант жилийн төсвийг төсөвлөн танилцуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.
- 8.4 Удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөлд улирал тутам, шаардлагатай үед санхүүгийн тайлан гаргаж танилцуулах, мэдээлэх ажлыг хариуцна.
- 8.5 ҮЭ-ийн санхүүгийн тайлан баланс, татварыг цаг тухай бүрд нь гарган, тооцоолж, харьяа төрийн байгууллагуудад тайлан, тэмдэгтийг хугацаанд нь тушаах.
- 8.6 ҮЭ-ийн бүх үйл ажиллагааг Хяналтын зөвлөлд ил тод мэдээлэх, явуулах.
- 8.7 ҮЭ-ийн дотоод журам, ёс зүйн дүрмийг чанд мөрдөх.
- 8.8 ҮЭ-ийн хорооны нягтлан бодогчийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө түдгэлзүүлнэ:
 - 8.8.1 Энэхүү дотоод журам болон хөлсөөр ажиллах гэрээг зөрчсөн.
 - 8.8.2 Өөрийн саналаар болон гэнэтийн хүчин зүйлээс хамааран.

- 8.8.3 Нийт тэргүүлэгч гишүүдийн гуравны хоёроос илүү нь ҮЭ-ийн хорооны нягтлан бодогчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл бүхий саналыг зөвшөөрсөн тохиолдолд.
- 8.8.4 ҮЭ-ийн өмч хөрөнгө, нэр хүндийн эсрэг ямар нэгэн санаатай болон санамсаргүй хийсэн үйл ажиллагаанд ногдуулах хариуцлагыг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, хөлсөөр ажиллах гэрээг мөрдлөг болгож Удирдах зөвлөл шийдвэрлэнэ.

Ес. ҮЭ-ийн Хяналтын зөвлөлийн эрх үүрэг

- 9.1 Хяналтын зөвлөл нь ёс зүйн дүрмийг мөрдлөг болгоно.
- 9.2 Хяналтын зөвлөл нь ҮЭ-ийн дүрэм, бүх гишүүдийн хурлын шийдвэрийн хэрэгжилт, санхүүгийн үйл ажиллагаа, хөрөнгийн зарцуулалт, гишүүдийн захидал, мэдээлэл, өргөдөл гомдлын барагдуулалтанд хяналт тавих эрхтэй.
- 9.3 Удирдах зөвлөлийн гишүүдийн сонгуулийн хуваарь гаргах, хянах, сонгогдсон гишүүнийг баталгаажуулах.
- 9.4 Хяналтын зөвлөл нь ҮЭ-ийн үйл ажиллагаа, санхүү, өмч хөрөнгийн ашиглалт, эзэмшлийг хянаж, баримт, аудитын шалгалт хийх ажлыг зохион байгуулна.
- 9.5 Хяналтын зөвлөл шаардлагатай үед зөвлөлдөх хурал зохион байгуулж болно.
- 9.6 Хууль болон дүрэмд нийцээгүй аливаа шийдвэрийг түдгэлзүүлэх санал Удирдах зөвлөлийн хуралд оруулах, шаардлагатай тохиолдолд бүх гишүүдийн хуралд оруулж хэлэлцүүлэн шийдвэрлүүлнэ.
- 9.7 ҮЭ-ийн дүрэм, ёс зүйн дүрэм зөрчсөн үйлдэлд хориг тавих, зөрчил гаргасан тэргүүлэгч гишүүнийг татан буулгах, сонгуульд нэр дэвших эрхийг нь түдгэлзүүлэх, захиргааны арга хэмжээ авах санал тус тус өгөх эрхтэй.
- 9.8 Удирдах зөвлөлийн сонгуулийн хувиарыг зарлах, хойшлуулах, нөхөн сонгуулийн товыг зарлах, цуцлах эрхтэй.
- 9.9 Хяналтын зөвлөл нь 3 гишүүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд 1 жилийн хугацаатай сонгуулийн журамд заасны дагуу ҮЭ-ийн гишүүдээс сонгоно.
- 9.10 Хяналтын зөвлөл нь ҮЭ-д жилд 1-ээс доошгүй удаа заавал аудитын шалгалт хийнэ.
- 9.11 Хяналтын зөвлөл нь шийдвэрээ тогтоол хэлбэрээр гаргах бөгөөд ҮЭ-ийн үйл ажиллагаанд тавих хяналтаа аливаа нэг тал, хувь хүний хүсэл зоригоос ангид ёс зүйн дүрмийг чандлан барьж хэрэгжүүлнэ.

Арав. ҮЭ-ийн өмч хөрөнгө

- 10.1 ҮЭ-ийн өмч хөрөнгө нь доорх эх үүсвэрээс бүрдэнэ.
- 10.1.1 Гишүүдийн татвар, хандив, үндсэн хөрөнгө
- 10.1.2 Банкны хүүгийн орлого
- 10.2 ҮЭХ нь өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллана.
- 10.3 ҮЭ-ийн өмч хөрөнгө халдашгүй бөгөөд төр, аж ахуй, улс төрийн болон бусад байгууллагууд ҮЭ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцож үл болно.
- 10.4 ҮЭ-ийн гишүүний татварыг Удирдах зөвлөлийн хурлаар тогтооно.

- 10.5 ҮЭ-ийн өмч хөрөнгийг шамшигдуулж, үрэгдүүлсэн тохиолдолд гэм буруутай этгээдэд Монгол улсын хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэж хохирлыг арилгуулахаар шүүх, хууль хяналтын байгууллагад нэхэмжилнэ.

Арван нэг. ҮЭ-ийн дотоод журмыг шинэчлэх, дахин найруулах

- 11.1 ҮЭ-ийн дотоод журмыг шинэчлэх, дахин найруулах эрх зөвхөн Удирдах зөвлөлийн гишүүдэд байх ба нийт тэргүүлэгчдийн дийлэнх олонхийн саналаар шинэчлэх, дахин найруулах асуудлыг авч хэлэлцэнэ.
- 11.2 Хяналтын зөвлөл журам батлалцахад хөндлөнгийн хянагчаар оролцоно.
- 11.3 ҮЭ-ийн дотоод журмыг батлах, шинэчлэх, дахин найруулсныг Удирдах зөвлөлийн бүх гишүүдийн гарын үсэг зурсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр гэж үзнэ.

Арван хоёр. Урамшуулал

- 12.1 Удирдах Зөвлөлийн гишүүнийг сар бүр, ҮЭХ Дарга, туслах ажилтан, нягтлан бодогчийг жилд нэг удаа урамшуулах бөгөөд урамшуулалын хэлбэр нь мөнгөн болон бусад хэлбэртэй байна.
- 12.2 ҮЭХ Дарга, туслах ажилтан, нягтлан бодогчийн урамшуулалыг үр дүнгийн гэрээ болон ажлын гүйцэтгэлийг харгалзан олгоно. Урамшуулал нь нэг сарын цалингийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал байна.
- 12.3 Удирдах Зөвлөлийн гишүүний урамшуулал нь сар бүр 150000 / нэг зуун тавин мянган төгрөг/ байна.